



МОНГОЛЫН САГСАН БӨМБӨГИЙН ХОЛБОО ТББ АЖЛЫН ХЭСГИЙН ШИЙДВЭР

Огноо 2022.04.07

№ 01

Улаанбаатар

Бүх гишүүдийн ээлжит бус
хурлын бэлтгэл хангах тухай

Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ /цаашид “Холбоо” гэх/-ын Тэргүүлэгчид /Удирдах зөвлөл/-ийн 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дугаар тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Бүх гишүүдийн ээлжит бус хуралд оролцох Төлөөлөгчдийн нэрсийг Холбооны гишүүнчлэлтэй, сагсан бөмбөгийн чиглэлээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг холбоодоос 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 18:00 цаг хүртэл хугацаанд хүлээн авч, нэрсийн жагсаалтыг гарган Төлөөлөгчдийг бүртгэлжүүлсүгэй.

2. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн материалыг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны 18:00 цаг хүртэл хугацаанд хүлээн авч, mglba.mn цахим хуудаст байршуулан нийтэд нээлттэй мэдээлсүгэй.

3. Холбооны шинэчилсэн дүрмийн төслийг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 18 цагаас өмнө mglba.mn цахим хуудаст байршуулан, ирүүлсэн саналыг хүлээж авч бүх гишүүдийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Т.Түвшинбаяр/-т даалгасугай.

4. Холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн дэнчинг Холбооны дансанд хүлээн авах боломжгүй байх тул дор дурдсан банкны түр дансаар хүлээн авч, Тэргүүлэгчдийн 2022 оны 01 дугаар тогтоолын Хавсралт 2-ийн 4, 5-т заасны дагуу холбогдох төлбөр тооцоо, шилжүүлгийг зохих ёсоор гүйцэтгэхийг Ажлын хэсгийн дарга Т.Түвшинбаяр болон Ажлын хэсгийн гишүүн Б.Баттөр нарт зөвшөөрсүгэй.

Банк: Худалдаа хөгжлийн банк
Данс: 470051977
Хүлээн авагч: Т.Түвшинбаяр
Г.Баттөр

5. Энэхүү шийдвэрийн 4-т дурдсан түр дансанд байршуулсан дэнчингийн хөрөнгөтэй холбоотой төлбөр тооцоог Тэргүүлэгчдийн 2022 оны 01 дугаар тогтоолын Хавсралт 2-ийн 4, 5-т заасны дагуу Бүх гишүүдийн хурлаас хойш 5 хоногийн дотор буюу 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бүрэн дуусгаж, Холбооны цаашидын үйл ажиллагааны санхүүжилтэд хандивласанд тооцон үлдээх хэсгийг Холбооны нэр дээрх банкны дансанд шилжүүлэн тус түр дансыг зохих журмын дагуу хаалгаж, хийгдсэн төлбөр тооцоо, шилжүүлэгтэй холбоотой мэдээллийг Ажлын хэсэгт ирүүлэхийг Ажлын хэсгийн дарга Т.Түвшинбаяр болон Ажлын хэсгийн гишүүн Б.Баттөр нарт үүрэг болгосугай.

6. Бүх гишүүдийн ээлжит бус хурлын товыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсгийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

7. Энэхүү шийдвэрийн биелэлтийг хариуцаж ажиллахыг Ажлын хэсгийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

Т.ТҮВШИНБАЯР

ГИШҮҮД:

М.ОТГОНБАЯР
С.ТӨГСЖАРГАЛ
Ц.МЭРГЭН
Г.БАТТӨР
Б.МЭНДСАЙХАН
Ө.МӨНХЧУЛУУН